

Орчны эрүүл мэндийн тухай ерөнхий ойлголт

ЭМГ-ын мэргэжилтэн П. Отгонбилэг

Тодорхойлолт

- **Эрүүл мэнд:**

- Өвчин осол гэмтлээс ангид байх төдийгүй нийгэм, бие бялдрын болон сэтгэцийн хувьд эрүүл байхыг

- **Орчин гэсэн ойлголтод :**

- Хүн, амьтан, ургамал оршин амьдарч, үйл ажиллагаа явуулж буй орчин болон тухайн үйл ажиллагаа явагдаж буй орчин

Орчин

- Байгаль орчин
- Нийгмийн орчин
- Хот суурины орчин
- Ажлын байрны/үйлдвэрийн орчин
- Сэтгэл зүйн орчин

Хүний эрүүл мэндэд үзүүлэх хүчин зүйл

- Физикийн
- Химийн
- Биологийн
- Нийгэм, сэтгэл зүйн

Орчноос хүний эрүүл мэндэд хүчин зүйлс хурц болон архаг нөлөө үзүүлнэ

ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭРХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Тоо	12	10	4
Эрх зүйн акт	Хууль	Стандарт	Хөтөлбөр
Нэр	<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн тухай хууль • Эрүүл ахуйн тухай хууль • Агаарын тухай хууль • Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль • Усны тухай хууль • Хог хаягдлын тухай хууль • Байгаль орчныг хамгаалах тухай хууль • Газрын тухай хууль • Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль • Ашигт малтмалын тухай хууль • Хот байгуулалтын тухай хууль • Барилгын тухай хууль 	<ul style="list-style-type: none"> • “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” MNS 6392:2013 • Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 • Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ. Техникийн шаардлага MNS 0900:2018 • Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 3297:2019 	<ul style="list-style-type: none"> • “Орчны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр • “Ус” үндэсний хөтөлбөр • “Уур амьсгалын өөрчлөлтийн” үндэсний хөтөлбөр • Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр

ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД ХӨТӨЛБӨРИЙГ 2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ”

- Агаарын чанарыг сайжруулж, агаарын бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах
- Ундны усны чанар, аюулгүй байдлыг хангаж, хөрсний бохирдлоос хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг бууруулах
- Орчны эрүүл мэндийн тандалт, судалгаа, үнэлгээний чанарыг сайжруулах
- Уур амьсгалын өөрчлөлтөөс хүний эрүүл мэндэд учирч болох аюул, эрсдэлийн үед хариу арга хэмжээ авах чадавхийг бэхжүүлэх
- Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах
- Хүний эрүүл мэндэд химийн бодисын үзүүлэх нөлөөллийг тандан судлах

Орчны эрүүл мэндийн тандалтын өнөөгийн байдал

- **Нийгмийн эрүүл мэнд** – Бүх нийтийн эрүүл мэндийг сайжруулах зорилготой – Эрүүл мэндийн асуудлыг хянах, дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах
- **Нийгмийн эрүүл мэндэд аюул учруулах зүйлс:** – Халдварт өвчний дэгдэлт (томуу, Эбола, КОВИД-19) – Архаг өвчин (ЗСӨ, хавдар, чихрийн шижин) – Орчны гамшигт үзэгдэл (хар салхи, газар хөдлөлт) – Биологийн болон химийн терроризим

Тандалтын тогтолцоо яагаад хэрэгтэй вэ?

- Эрүүл мэндийн асуудлын цар хүрээг үнэлэх
- Тухайн асуудал хаана их тохиолдож байгааг тодорхойлох /эрсдэлт бүлгийг илрүүлэх/
- Өвчний эмгэг жамыг тодорхойлох
- Асуудлыг тодорхойлох эсвэл дэгдэлтийг эрт илрүүлэх
- Судалгааны таамаглал бий болгох
- Халдварт өвчин үүсгэгчийн өөрчлөлтийг хянах
- Эрүүл мэндийн практикт гарсан өөрчлөлтийг илрүүлэх
- Ноцтой байдал/яаралтай хариу арга хэмжээг хөнгөвчлөх
- Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх

НЭМҮТ- Орчны эрүүл мэндийн тандалт/бүтэц/

- Үндэсний хэмжээнд тандалт, судалгаа хийх, дүгнэлт гаргах, мэдээ, мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээг төлөвлөх ажлыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн тандалт, судалгааны асуудал хариуцсан нэгж (цаашид “тандалтын нэгж” гэх) гүйцэтгэнэ
- Аймгийн хэмжээнд – НЭМТ - Орчны эрүүл мэнд, нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

НЭМҮТ- Орчны эрүүл мэндийн тандалт

□ Эрүүл ахуйн асуудал хариуцсан бүх шатны байгууллага нь хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг урьдчилан тогтоож, эрсдэлийг бууруулах талаар авсан арга хэмжээний тухай мэдээ, мэдээлэл, хариуцсан нутаг дэвсгэр, салбарын хэмжээнд хийсэн тандалт, судалгааны дүнг хугацаа харгалзахгүй тандалтын нэгжид хүргүүлнэ.

□ Тандалтын нэгж нь монгол орны газар зүйн байршил, уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар, хүрээлэн байгаа орчны бохирдлоос хамааран хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тандан судалж олон нийтэд мэдээлж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа